



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/361

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолын хавсралтын “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого” 2.4.5.4-р заалт, Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банк хооронд 2013 оны 2 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр - 5 төслийн 2963-MON тоот гэрээний Хавсралт 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цус сэлбэлт судлалын үндэсний төв болон Цусны салбар төвүүдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг зохицуулан ажиллах журам”-ыг нэгдүгээр, “Засвар үйлчилгээ хийх захиалга болон хүлээлцэх маягт”-ыг хоёрдугаар, “Инженер, техникийн ажилчдад тавигдах мэргэжлийн шаардлага”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Цус сэлбэлт судлалын үндэсний төв /Н.Эрдэнэбаяр/, Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газар /Л.Мөнхтулга/-т даалгасугай.


САЙДЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЦОГЦЭЦЭГ

081151

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 09 сарын 14-ны өдрийн  
А/... дугаар тушаалын 1 дүгээр хавсралт  
1361



## **ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ БОЛОН ЦУСНЫ САЛБАР ТӨВҮҮДИЙН ЭМНЭЛГИЙН БОЛОН ЭМНЭЛГИЙН БУС ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАН АЖИЛЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдэд ашиглагдаж байгаа Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн арчилгаа, засвар үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдэд ашиглагдаж байгаа Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн аюулгүй, хэвийн, найдвартай үйл ажиллагааг хангах, үүнтэй холбогдуулан гарах харилцааг зохицуулахад журмын гол зорилго оршино.

1.3. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасаг нь Эрүүл мэнд, спортын сайдын “Эмнэлгийн тоног төхөөрөмж, шалгалт тохируулга хийх” журам батлах тухай 2015 оны 249 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх” тухай 2013 оны 140 дүгээр тушаал, “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг зохицуулах” тухай 2005 оны 298 дугаар тушаал болон бусад тушаал шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

1.4. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасаг нь Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн бүтцэд ажиллана.

### **Хоёр. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасгийн бүтэц, орон тоо**

2.1. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасаг нь дараах инженер, техникийн мэргэжлийн ажилтантай байна.

2.1.1. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасгийн инженер-менежер, эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, хөргөлтийн тоног төхөөрөмжийн инженер, мэдээллийн технологийн инженер, эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч зэрэг байна.

2.1.2. Ажлын цар хүрээ, ачааллаас хамаарч инженер, техникчдын орон тоог нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагад танилцуулан шийдвэрлүүлнэ.

2.2. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасгийн үйл ажиллагаа явуулах ажлын байр нь дараах зохион байгуулалттай байна. Үүнд: Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж хүлээн авах, тоног төхөөрөмж ариутгах, электроник, механикийн засвар үйлчилгээ, тоног төхөөрөмж хүлээлгэн өгөх хэсэг болон инженер, техникч, сэлбэг материал хадгалах өрөөнүүдээс бүрдэнэ.



2.3. Энэхүү тасгийн инженер, техникийн ажилчдыг сонгон шалгаруулахдаа ажлын байранд тавигдах мэргэжлийн шаардлага болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

### **Гурав. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл**

3.1. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн аюулгүй, хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хугацаанд нь тасралтгүй, тогтмол явуулах;

3.2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл, мэдээлэлд Олон улсын нэршлийн "UMDNS" системийг ашиглах, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг вэб/интернетэд суурилсан програм хангамж ашиглан баримтжуулж, Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдийн үйл ажиллагаанд нэвтрүүлж хэвшүүлэх;

3.3. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалтын ажлыг хариуцаж холбогдох байгууллагаар гүйцэтгүүлэх;

3.4. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдэд ашиглагдаж байгаа вэб/интернетэд суурилсан програм хангамжийг салбарын хөрөнгийн төлөвлөлтийн програм хангамжтай уялдуулж ашиглах ба нэршил, код нь ижил байна;

3.5. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн шинэчлэл, сэлбэг хэрэгслийн захиалгыг хүлээн авах, нэгтгэх, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эмнэлгийн тоног төхөөрөмжийн алба, Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлнэ;

### **Дөрөв. Мэдээллийн технологи, инженер, техникийн тасгийн үйл ажиллагаа, хамрах хүрээ**

4.1. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдэд ашиглагдаж байгаа Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн төлөвлөгөөт арчилгаа, засвар үйлчилгээг гүйцэтгэх, илэрсэн гэмтлийг засварлах, гэнэтийн гарч болох эвдрэл гэмтлийг салбар төвүүдийн инженер, техникчтэй хамтран хугацаа алдалгүй арилгах;

4.2. Вэб/интернетэд суурилсан програм хангамжийг үйл ажиллагаандаа ашиглах;

4.3. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт хийлгэх хуваарийг боловсруулан гаргах, хяналт тавих, холбогдох байгууллагаар баталгаажуулах;

4.4. Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвүүдийн хэмжээнд шинэ техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

4.5. Ханган нийлүүлэгч байгууллага болон мэргэжлийн байгууллагаар хийлгэх засвар үйлчилгээний ажилд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд



ханган нийлүүлэгч байгууллагатай засвар үйлчилгээний гэрээний төслийг боловсруулж байгууллагын удирдлагаар батлуулж, хамтарч ажиллах;

4.6. Цусны салбар төвүүдэд ашиглагдаж буй эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжид шаардагдах засвар үйлчилгээний ажлын зардал, сэлбэг материал, томилолтын зардал зэргийг тооцон, дүн мэдээллийг дараа жилийн төсөв батлагдах хугацаанаас өмнө салбар төвүүдэд хүргүүлж улмаар Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн төсөвт тусгах санал боловсруулах;

4.7. Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн хэрэглэгчдэд мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх, угсралт, суурилуулалт, ашиглалт, аюулгүй ажиллагаа, арчилгаа, засвар үйлчилгээний сургалтыг зохион байгуулах;

4.8. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн каталог, ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага, электрон эд ангийн лавлах бүхий техникийн номын сантай байх;

4.9. Монгол улсад эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын болон гадаадын байгууллагуудтай холбоо тогтоож туршлага судлах, хамтран ажиллах;

4.10. Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн цахилгааны аюулгүй байдлыг хангаж хөдөлмөр аюулгүй ажиллагааны зааврыг мөрдөн ажиллах.

#### **Тав. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүлээх үүрэг**

5.1. Цусны салбар төвийн засвар, үйлчилгээ хийлгэх шаардлагатай эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийг маягтын дагуу бөглөж, Мэдээллийн технологи, инженер, техникийн тасагт ирүүлэх;

5.2. Цусны салбар төвийн эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт явуулах орчинг бүрдүүлэх (өрөө, цахилгаан, газардуулга гэх мэт);

5.3. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв нь жил бүр Цусны салбар төвийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт, засвар үйлчилгээ, түүний сэлбэг материал, томилолтын зардлыг төсөвтөө суулгах (хугацаат сэлбэг материал, ажил үйлчилгээ, томилолтын зардал);

5.4. Цусны салбар төвд ашиглагдаж байгаа эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн бүртгэлийг вэб/интернетэд суурилсан програм хангамжийг ашиглан тогтмол шинэчлэх;

5.5. Цусны салбар төвийн эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, холбогдох тооцоо, судалгааг Цус сэлблэт судлалын үндэсний төвийн Мэдээллийн технологи, инженер, техникийн тасагтай хамтран зохион байгуулах, хяналт тавих ажилтанг томилох;

**Зургаа. Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Цусны салбар төвийн тоног төхөөрөмж хариуцсан инженер, техникийн ажилтны хүлээх үүрэг**

6.1.Цусны салбар төвд ашиглагдаж буй эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн өдөр, сар, улирал, жилээр хийгдэх төлөвлөгөөт арчилгаа, үйлчилгээг хийж гүйцэтгэх;

6.2.Цусны салбар төвд ашиглагдаж буй эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн хугацаат сэлбэгийн тооцоо, судалгааг гаргах;

6.3.Цусны салбар төвд ашиглагдаж буй эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний ажлын захиалгыг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн Мэдээллийн технологи, инженер, техникийн тасагт өгөх, шаардлагатай тохиолдолд засвар үйлчилгээг өөрсдөө хариуцан хийх;

6.4.Цусны салбар төвд ашиглагдаж буй хөрөнгийн болон засвар, үйлчилгээний мэдээллийг вэб/интернетэд суурилсан програмд тухай бүр оруулж бүртгэл хийх;

6.5.Засвар үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн ашиглалтын болон засварын гарын авлагыг бэлэн байлгах;



Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 09 сарын 14-ны өдрийн  
дугаар тушаалын 2 дугаар хавсралт



**Засвар үйлчилгээ хийх захиалга болон хүлээлцэх маягт**

Тоног төхөөрөмжийн нэр:

Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгч:

Тоног төхөөрөмжийн загвар:

Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэсэн он:

Тоног төхөөрөмжийн серийн дугаар:

<b>Засвар үйлчилгээ хийлгүүлэх хүсэлт гаргах:</b>			
Байгууллагын нэр	.....		
Тасаг, албаны нэр	.....		
Ажлын захиалгын дугаар	.....		
Эмнэлгийн ажилтан, оператор, техникч нь шалтгааныг тайлбарласан / тодорхойлсон	.....		
Тоног төхөөрөмжийн байршил	.....		
Эвдрэл гэмтлийн шалтгаан	.....		
Огноо	.....		
<b>Засвар үйлчилгээ хийсэн ажлын тэмдэглэл</b>			
Засвар үйлчилгээ хийсэн инженер/техникчийн нэр	.....	Ажлыг эхлүүлсэн огноо	.....
Хийгдсэн ажил	.....		
Эвдрэл гэмтэл бүрэн засагдсан уу?	.....		
Үгүй бол дараагийн ямар ажил хийгдэх вэ?	.....		
Дараагийн төлөвлөсөн ажил хэзээ дуусах вэ?	.....		
<b>Үргэлжлэн явагдах дараагийн ажлын тэмдэглэл</b>			
Засвар үйлчилгээний инженер/техникчийн нэр	.....	Ажлыг эхлүүлсэн огноо	.....
Хийгдсэн ажил	.....		
Эвдрэл гэмтэл бүрэн засагдсан уу?	.....		
Үгүй бол дараагийн ямар ажил хийгдэх вэ?	.....		
Шалтгаан?	.....		

Засварын хүсэлт гаргасан:...../.....

### Засварласан тоног төхөөрөмж хүлээлцэх маягт

Огноо .....

Техник, тоног төхөөрөмжийн нэр .....

Техник, тоног төхөөрөмжийн загвар .....

Серийн дугаар .....

<b>Дэлгэрэнгүй мэдээлэл</b>	
Ажлын захиалгын дугаар	.....
Засварын тэмдэглэл	..... .....
Ажиллагааг шалгасан тэмдэглэл	..... .....
Техник, тоног төхөөрөмжтэй холбоотой бусад тайлбар	..... .....

<b>Хүлээлцсэн</b>	
Хүлээлгэн өгсөн ажилтан	.....
Хүлээн авсан ажилтан	.....
Огноо	.....

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 09 сарын 14-ны өдрийн  
А... дугаар тушаалын 3 дугаар хавсралт  
361



**Мэдээллийн технологи, инженер, техникийн тасгийн инженер, техникийн ажилчдад тавигдах мэргэжлийн шаардлага**

**1. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер-менежерийн ажлын байранд тавигдах шаардлага:**

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, бакалаврын зэрэгтэй ба мэргэжил дээшлүүлсэн байх
- Англи хэлний мэдлэгтэй байх /ярих, сонсох, бичих чадвартай/
- Эмнэлгийн техникийн холбогдолтой материалыг орчуулах, англи хэл дээрх материалыг өдөр тутмын ажилдаа ашиглах чадвартай байх
- Электрон техникийн схем уншиж ойлгох, тайлбарлах чадвартай байх
- Ажил зохион байгуулах, бусдыг удирдаж ажиллах чадвартай байх
- Эмнэлгийн техникийн ашиглалт, засвар үйлчилгээ, худалдаа хангамжийн асуудлаар эмнэлгийн удирдлага болон ажилтнуудад мэргэжлийн зааварчилгаа, зөвлөмж өгөх чадвартай байх
- Эмнэлгийн техникийн аюулгүй ажиллагаа, чанарын баталгааны асуудлыг хариуцаж ажиллах чадвартай байх
- Байгууллагын хэмжээний тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээний хэтийн төлөвийг боловсруулах, төсөв тооцоог хийх чадвартай байх
- Сургалт зохион байгуулах, хичээл заах чадвартай байх
- Технологийн талаарх судалгаа хийх чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний програмуудыг ашиглаж ажиллах чадвартай байх
- Цахим сүлжээ, програм хангамж, интернет орчинд ажиллах чадвартай байх



## **2. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженерийн ажлын байранд тавигдах шаардлага:**

- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чиглэлээр мэргэжил эзэмшсэн, бакалаврын зэрэгтэй ба мэргэжил дээшлүүлсэн байх
- Тоног төхөөрөмжийн эвдрэл оношлох, засвар үйлчилгээ хийх чадвартай
- Англи хэлний мэдлэгтэй байх /ярих, сонсох, бичих чадвартай байх/
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн холбогдолтой материалыг орчуулах, англи хэл дээрх материалыг өдөр тутмын ажилдаа ашиглах чадвартай байх
- Электрон техникийн схем уншиж ойлгох, тайлбарлах чадвартай байх
- Мэдээллийн бүртгэл, тайлан хөтлөх чадвартай байх
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, худалдаа хангамжийн асуудлаар эмнэлгийн удирдлага болон ажилтнуудад мэргэжлийн зааварчилгаа, зөвлөмж өгөх, багаар ажиллах чадвартай байх
- Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, чанарын баталгааны асуудлыг хариуцаж ажиллах чадвартай байх
- Байгууллагын хэмжээний тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээний хэтийн төлөвийг боловсруулах, төсөв тооцоог хийх чадвартай байх
- Сургалт зохион байгуулах, хичээл заах чадвартай байх
- Технологийн талаарх судалгаа хийх чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний програмуудыг ашиглаж ажиллах чадвартай байх
- Цахим сүлжээ, програм хангамж, интернет орчинд ажиллах чадвартай байх

## **3. Програм хангамж, цахим техник, сүлжээний инженерийн ажлын байранд тавигдах шаардлага:**

- Програм хангамж, цахим техник, сүлжээний чиглэлээр мэргэжил эзэмшсэн байх, бакалаврын зэрэгтэй ба мэргэжил дээшлүүлсэн байх
- Цахим техникийн эвдрэл оношлох, засвар үйлчилгээ хийх чадвартай
- Англи хэлний мэдлэгтэй байх /ярих, сонсох, бичих чадвартай байх/
- Цахим техниктэй холбогдолтой материалыг орчуулах, англи хэл дээрх материалыг өдөр тутмын ажилдаа ашиглах чадвартай байх
- Мэдээллийн бүртгэл, тайлан хөтлөх чадвартай байх
- Цахим техник, програм хангамж, сүлжээний талаар эмнэлгийн удирдлага болон ажилтанд мэргэжлийн зааварчилгаа, зөвлөмж өгөх, багаар ажиллах чадвартай байх
- Цахим техникийн хангамж, засвар үйлчилгээний хэтийн төлөвийг боловсруулах, төсөв тооцоог хийх чадвартай байх
- Сургалт зохион байгуулах, хичээл заах чадвартай байх
- Технологийн талаарх судалгаа хийх чадвартай байх

- Компьютерийн хэрэглээний програмууд, цахим сүлжээ, програм хангамж, интернетийн талаар хичээл заах чадвартай байх

**4. Хөргөлтийн тоног төхөөрөмжийн инженерийн ажлын байранд тавигдах шаардлага:**

- Хөргөлтийн техник, тоног төхөөрөмжийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй ба мэргэжил дээшлүүлсэн байх,
- Тоног төхөөрөмжийн эвдрэл оношлох, засвар үйлчилгээ хийх чадвартай
- Англи хэлний мэдлэгтэй байх /ярих, сонсох, бичих чадвартай байх/
- Хөргөлтийн техник, тоног төхөөрөмжтэй холбогдолтой материалыг орчуулах, англи хэл дээрх материалыг өдөр тутмын ажилдаа ашиглах чадвартай байх
- Электрон техникийн схем уншиж ойлгох, тайлбарлах чадвартай байх
- Мэдээллийн бүртгэл, тайлан хөтлөх чадвартай байх
- Хөргөлтийн техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, худалдаа хангамжийн асуудлаар эмнэлгийн удирдлага болон ажилтнуудад мэргэжлийн зааварчилгаа, зөвлөмж өгөх, багаар ажиллах чадвартай байх
- Хөргөлтийн техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, чанарын баталгааны асуудлыг хариуцаж ажиллах чадвартай байх
- Байгууллагын хэмжээний хөргөлтийн тоног төхөөрөмжийн хангамж, засвар үйлчилгээний хэтийн төлөвийг боловсруулах, төсөв тооцоог хийх чадвартай байх
- Сургалт зохион байгуулах, хичээл заах чадвартай байх
- Технологийн талаарх судалгаа хийх чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний програмуудыг ашиглаж ажиллах чадвартай байх
- Цахим сүлжээ, програм хангамж, интернет орчинд ажиллах чадвартай байх

**5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникчийн ажлын байранд тавигдах шаардлага:**

- Техникийн чиглэлээр техникум, коллеж төгссөн мэргэжлийн зэрэгтэй, мэргэжил дээшлүүлсэн байх
- Англи хэлний мэдлэгтэй байх /сонсох, бичих чадвартай/
- Электрон техникийн схемийг уншиж ойлгох чадвартай байх
- Техникийн үзлэг үйлчилгээг хуваарийн дагуу хийх чадвартай байх
- Инженерийн удирдлага дор засвар үйлчилгээ хийх чадвартай байх
- Багаар ажиллах чадвартай байх
- Компьютерийн хэрэглээний програмуудыг ашиглаж ажиллах чадвартай байх
- Цахим сүлжээ, програм хангамж, интернет орчинд ажиллах чадвартай байх